

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/52/СТА-ТӨҮГ

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ӨБЦДС	Өмнөд бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЦДҮС	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	5
	2.1. Оршил	5
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
	2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл.....	9
	2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал	10
	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал	10
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
	2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
	2.11. Шилэн дансны мэдээлэл	11
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3	Менежментийн захидал	12
	3.1 Хууль эрх зүйн -тэй холбоотой асуудал	12
	3.1.1 Илрүүлэлт:	12
	3.1.2 Эрсдэл:.....	12
	3.1.3 Өгсөн зөвлөмж:.....	12
	3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	13
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
	4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	14
	4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	16
	4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	17
	4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	19



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

“ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Т.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

2019. 03. 20 № 06/510
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу, тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Т.Жаргалсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрөөс 2019 оны 03 дугаар сарын 13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 3 дугаар сарын 15 -ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн “Номгон аудит” ХХК-ийн аудитор Г.Саранчимэг, Л.Соёлмаа, Б.Давгабазар нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг “Номгон аудит” ХХК-д 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 02/59 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

"Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Дэвшилтэт технологийг нэвтрүүлэн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр тасралтгүй найдвартай хангаж, түгээсэн эрчим хүчийг борлуулж хэрэглэгчдээ дээдлэн ажиллах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Засгийн газрын 2015 оны 1 дүгээр сарын 05-ны өдрийн 03 дугаар тогтоолоор “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цахилгаанаар зохицуулалттай хангах
- Цахилгаан түгээх
- 0.4-35 кВ-ын ЦДШ, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга
- Тоолуур хэмжих хэрэгслийн засварлах, суурилуулах

"Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

"Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөрлийн тухай хууль
- Компанийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Татварын болон НДШ-ийн багц хуулиуд

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан талаар дараах заалтад тэмдэглэв. Үүнд

Монгол улсын засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 335 дугаар тогтоолоороор Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж “Эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудын хувьцааны 70 хувийг Эрчим хүчний яам, 30 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тус тус эзэмшиж, компанийн Хувьцаа эзэмшигчдын хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийг төлөөлөх этгээдийг томилж чөлөөлнө” гэсэн нэмэлт өөрчлөлт орсон байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

"Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Апех” програм хангамж ашигладаг байна.

"Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 13 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт зардлын нэг хувиар сонгов.

Энэ нь нийт болон цэвэр хөрөнгөнөөс материаллаг түвшинг тогтооход материаллаг түвшин өндөр гарч байгаа тул нийт зардлын нэг хувиар тогтоох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

"Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 11,887.3 сая төгрөг бөгөөд түүний нэг хувь болох 118.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг нэг хувиар тооцсон нь эрсдэл дундаж түвшинд гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 13 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд газар эзэмших эрхийн 542.8 сая төгрөгийг бусад үндсэн хөрөнгө дансанд бүртгэснийг, үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлгээний тайланг дахин хянах явцад нэмэгдсэн газар эзэмших эрхийн үнэ 233.0 сая төгрөг, барилга байгууламжийн үнэ 295.5 сая төгрөг нийт 1,071.3 сая төгрөгийг алдааг аудитын явцад залруулсан
- Сангийн яамтай байгуулсан урт хугацаат зээлийн гэрээгээр, зээлийн хөрөнгө шилжиж ирсэн өдрөөс буюу (2013-2017) оны хүүгийн зардал “ӨБЦТС” ТӨХК нөхөн төлөх 28.6 сая төгрөг, 2018 оны хүүгийн зардал 5.6 сая нийт 34.2 сая төгрөгийг аудитын явцад залруулсан
- Нийгмийн даатгалын сангаас үзүүлсэн хөнгөлөлтийн орлого 4.6 сая төгрөгийг аудитын явцад залруулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	73.7	Сангийн яам ба “ӨБЦТС” ТӨХК-ийн хооронд байгуулсан дамжуулан зээлэх гэрээний үүргийг хэрэгжүүлэх
	Дүн	1	73.7	

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 273 дугаар тогтоолыг үндэслэн “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн захирлын 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн “Үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэн бүртгэх тухай” А/12 дугаар тушаалын хэрэгжилт, “Апех” програмд тохиргоо хийгдээгүйн улмаас дахин үнэлсэн үл хөдлөх хөрөнгийг барилга байгууламж бүлэгт “Дахин үнэлэгдсэн хөрөнгө” нэрээр бүртгэсэн байгааг дахин нягтлах шаардлагатай.

Хөрөнгийн үнэлгээг “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн захирлын тушаалаар томилогдсон баг гүйцэтгэсэн бөгөөд үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нягтлан шалгалтын ажлыг 071200049 дугаарын тусгай зөвшөөрөлтэй хөндлөнгийн хараат бус хөрөнгийн үнэлгээчин Ш.Уртнасан дүгнэлт гаргасан байна.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Тайлант жилд 62.2 сая кВт.ц цахилгаан эрчим хүчийг 8,437.3 сая төгрөгөөр худалдан авч, 55.2 сая кВт.ц цахилгаан эрчим хүчийг 8,654.2 сая төгрөгөөр борлуулж, нийт 11,952.5 сая төгрөгийн орлоготой 11,887.3 сая төгрөгийн зардалтай 83.3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. 2018 онд түгээлтийн алдагдлыг 15 хувиар тооцож төлөвлөсөн гүйцэтгэлээр 11.9 хувийн алдагдалтай ажиллаж 3.1 хувиар бууруулсан. Үйл ажиллагааны зардлын 71 хувийг худалдан авсан цахилгаан эрчим хүчний зардал эзэлсэн байна. Худалдан авсан цахилгааны зардал төлөвлөснөөс 1,987.8 сая төгрөгөөр хэтэрсэн нь ЭХЗХ-ноос тарифын зохицуулалт хийж “ЦДҮС” ТӨХК-иас худалдаж авах цахилгаан эрчим хүчний үнэ 11-12 сард (1 кВт) цагийн тариф 15.5-68.88 төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой. Зорилтот түвшингээр батлагдсан авлага 144.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь НӨАТ-ийн 52.4

сая төгрөг, ААНОАТ-ийн 88.0 сая төгрөг, нэг худалдан авагчид төлсөн урдчилгаа төлөлт 7.0 сая төгрөг байна. 2018 оны хөрөнгө оруулалт, их засварын ажлыг тендер шалгаруулалтын аргаар гүйцэтгэж 621.9 сая төгрөгийн ажлыг 100 хувь хүлээн авсан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн шилэн дансны нэгдсэн Shilendans.gov.mn, “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6-д зааснаар 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ТӨБЗ-ийн газрын 2017 оны 677 дугаар тогтоолоор батлуулан байршуулсан ба хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл 16, бонд, зээл, өрийн бичиг баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүссэн аливаа шийдвэр 42, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл 20, худалдан авах ажиллагааны тайлан зэрэг нийт 79 мэдээлэл байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Урт хугацаат зээлтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Сангийн яам ба “ӨБЦТС” ТӨХК-ийн хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх 2018 оны 4 дүгээр сарын 4 өдрийн 25 тоот гэрээнд заасан зээл, зээлийн хүүгийн төлбөр 73.7 сая төгрөгийн төлөх хугацааг 14-29 хоног хэтрүүлэн төлсөн байна.

Энэ нь гэрээний 2.1.2 “Үндсэн болон хүүгийн төлбөрийг жил бүрийн 5 дугаар сарын 01-ний өдөр ба 11 дүгээр сарын 01-ний өдөр гүйцэтгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Зээлийн гэрээний 4 дүгээр зүйлийн 4.1 заасны дагуу “... үүргээ хэсэгчлэн биелүүлээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувийн алданги тооцож үл маргалдах журмаар гаргуулах эрхтэй”

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Урт хугацаат зээлийн эргэн төлөлтөнд анхааран ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 10 -ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12 дугаар сарын 31	2018 оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	976,809,138.99	847,809,491.00
1.1.2	Дансны авлага	31,546,509.34	71,396,499.90
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	18,878,776.11	140,618,112.75
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	100,764,543.62	129,810,672.45
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	9,333,519.91	9,083,519.91
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	31,709,681.78	31,709,681.78
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,169,042,169.74	1,230,427,977.78
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	15,500,267,289.68	15,999,569,957.90
1.2.2	Биет бус хөрөнгө	6,528,841.74	780,970,900.10
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	15,506,796,131.41	16,780,540,858.00
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	16,675,838,301.16	18,010,968,835.78
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	2,341,994.03	7,711,913.19
2.1.1.2	Цалингийн өглөг		171,905.53
2.1.1.3	Татварын өр	6,718,527.21	

2.1.1.4	НДШ–ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	21,102,581.00	47,235,016.00
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	50,874,504.66	35,248,188.66
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	81,037,606.91	90,367,023.37
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	686,882,621.51	533,520,000.00
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	686,882,621.51	533,520,000.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	767,920,228.42	623,887,023.37
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	15,239,713,592.68	15,596,367,727.68
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		621,749,200.00
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	330,474,655.39	867,017,790.66
2.3.9	Хуримтлагдсан ашиг	337,729,824.67	301,947,094.07
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	15,907,918,072.74	17,387,081,812.41
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	16,675,838,301.16	18,010,968,835.78

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	8,227,580,862.72	11,626,722,813.34
2	Борлуулалтын өртөг	6,703,871,110.94	10,601,992,407.63
3	Нийт ашиг(алдагдал)	1,523,709,751.78	1,024,730,405.72
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	76,701,993.88	103,557,039.42
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	196,764,327.16	226,897,806.23
9	Борлуулалт, маркетингийн зардал	5,600,034.55	6,919,730.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	985,586,030.03	1,155,709,353.56
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	3,515,497.05	3,940,072.08
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	(77,863,192.36)	(94,958,789.81)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	724,611,318.83	93,657,305.91
19	Орлогын татварын зардал	72,461,131.88	10,355,703.94
20	Татварын дараах ашиг (алдагдал)	652,150,186.94	83,301,601.96
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	652,150,186.94	83,301,601.96
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	652,150,186.94	83,301,604.96

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин элгээний нэмэгдэл	Дийн өмчийн бусад хэсэг	Грифтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл	14,240,798,494.53		370,127,983.39	(287,425,882.27)	14,323,500,595.65
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(0.01)	(0.01)
3	Залруулсан үлдэгдэл	14,240,798,494.53		370,127,983.39	(287,425,882.28)	14,323,500,595.64
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				652,150,186.94	652,150,186.94
5	Бусад дэлгэрэнгүй орлого					
6	Өмчид гарсан өөрчлөлт	998,915,098.15		(39,653,328.00)		959,261,770.15
7	Зарласан ногдол ашиг				(26,994,480.00)	(26,994,480.00)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
9	2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	15,239,713,592.68		330,474,655.39	337,729,824.67	15,907,918,072.74
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө,				(53,869,312.56)	(53,869,312,56)

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

	алдааны залруулга					
11	Залруулсан үлдэгдэл	15,239,713,592.68		330,474,655.39	283,860,512.11	15,854,048,760.18
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				83,301,601.96	83,301,601.96
13	Бусад дэлгэрэнгүй орлого					
14	Өмчид гарсан өөрчлөлт	356,654,135.00		536,543,135.27		893,197,270.27
15	Зарласан ногдол ашиг				(65,215,020)	(65,215,020,00)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		621,749,200.00			621,749,200.00
17	2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	15,596,367,727.68	621,729,200.00	867,017,790,66	301,947,094.07	17,387,081,812.41

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,523,459,992.91	9,901,074,932.05
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	6,181,575,909.09	9,669,980,495.03
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	341,884,083.82	231,094,437.02
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,402,021,747.92	9,509,378,405.49
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,207,018,384.08	1,579,493,910.30
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	308,420,000.00	396,981,598.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,672,593,644.28	6,253,015,194.16
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	17,969,399.59	18,264,758.35
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	67,229,641.00	73,783,394.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		34,283,723.83
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	517,943,041.00	610,923,001.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	7,392,760.00	9,455,962.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	603,454,877.97	533,176,863.85
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,121,438,244.98	391,696,526.56
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	77,549,288.88	100,820,258.72
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	847,295.00	5,544,144.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	76,701,993.88	95,276,114.72
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	764,323,358.45	517,051,889.00

2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	764,323,358.45	517,051,889.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6			
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(686,774,069.57)	(416,231,630.28)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		272,727.27
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан47		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		272,727.27
3.1.4			
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	26,994,480.00	104,737,271.51
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		39,522,251.51
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг	26,994,480.00	65,215,020.00
3.2.5			
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(26,994,480.00)	(104,464,544.24)
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	407,669,695.41	(128,999,647.96)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	569,139,443.58	976,809,138.96
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	976,809,138.96	847,809,491.00

2018 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН БИЕЛЭЛТ

д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2017 оны мөн үе	2018 оны Жилийн эцэс		Харьцуулалт /хувь/	
				Төлөв лөгөө	Гүйцэт гэл	Өмнөх оны мөн үетэй	Төлөв лөгөөтэй
1	Худалдаж авсан цахилгаан	сая кВт.ц	43.3	51.6	62.7	144.7	121.5
2	ЦЭХ-ний түгээлтийн алдагдал: хувиар	хувь	12.8	15.0	11.9	(0.9)	(3.1)
	биетээр	сая кВт.ц	5.5	7.7	7.5	134.6	96.3
3	Борлуулах цахилгаан эрчим хүч	сая кВт.ц	37.8	43.9	55.2	146.2	125.9
4	Нийт орлого	сая төг	8,501.0	10,201.1	11,957.2	140.7	117.2
	Үүнээс: Борлуулалтын орлого	сая төг	5,440.2	6,988.6	8,654.2	159.1	123.8
	Түгээх үйлчилгээний төлбөр	сая төг	2,787.4	2,972.5	2,972.5	106.6	100.0
5	Нийт зардал	сая төг	7,776.4	10,043.9	11,863.5	152.6	118.1
	Үүнээс: Удирдлагын зардал	сая төг	81.1	113.5	118.5	146.1	104.4
6	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	сая төг	724.6	157.3	93.7	12.9	59.6
	Цэвэр ашиг /алдагдал/	сая төг	652.2	141.5	83.3	12.8	58.9
	Төрийн өмчийн ногдол ашиг	сая төг	27.0	31.3	65.2	241.6	208.4
7	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	0.91	0.98	0.99	92.9	99.2
8	Нийт авлага	сая төг	50.4	67.5	212.0	74.7	31.8
	Үүнээс: Цахилгааны авлага	сая төг	17.8	63.0	62.3	28.3	101.1
9	Нийт өр төлбөр	сая төг	767.9	620.5	623.9	123.7	99.5
	Үүнээс: Богино хугацаат өглөг	сая төг	81.0	87.0	90.4	93.1	96.3
10	ТЗБАХ, Хөрөнгө оруулалт, их засвар	сая төг	995.8	650.8	621.9	62.5	95.6
11	Нийт ажиллагсдын тоо	хүн	87.0	94.0	90.0	103.4	95.7
12	Нийт цалингийн сан	сая төг	1,343.3	1,731.8	1,612.5	120.0	93.1

5 5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код:
2019.03.15			САГ-2019/52СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК		сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөн гөн дүн	Аудитын байгуул агаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Сангийн яам ба “ӨБЦТС” ТӨХК-ийн хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх 2018 оны 4 дүгээр сарын 4 өдрийн 25 тоот гэрээнд заасан зээл, зээлийн хүүгийн төлбөр 73.7 сая төгрөгийн төлөх хугацааг 14-29 хоног хэтрүүлэн төлсөн байна.	73.7	Зөвлөмж	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Т.Жаргалсайхан М.Өлзийнэмэх

